



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 442

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.4 дэх хэсэг, 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дундговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өргөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон 18,500,000.00 (арван найман сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.
2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

 - 2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэг, материал болгон ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
 - 2.2. Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг (худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;
 - 2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
 - 2.4. Арга хэмжээний биелэлтийг акталж данснаас хассан тээврийн хэрэгслийн улсын дугаарыг улсын бүртгэлээс хассан тодорхойлолтын хамт 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

З.МЭНДСАЙХАН

А.АРИУНБОЛД



000003-

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн
442 дугаар тогтоопын хавсралт

ДУНДГОВЬ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

| Д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | Тоо хэмжээ (ш) | Нийт гүйлт (км) | Балансын үнэ (төгрөг) | Хурийтлагдсан элгэдэл (төгрөг) | Үлдэгдэл ёртөг (төгрөг) |
|-----|---------------------------------------|------------------------|----------------|-----------------|-------------------------------|--------------------------------|-------------------------|
| 1 | Автомашин "УАЗ-220692-033", ДУА 09-09 | 2010 | 1 | 125616 | 18,500,000.00 | 18,500,000.00 | 0.00 |
| | НИЙТ ДҮН | | | | 18,500,000.00 | 18,500,000.00 | - |
| | | | | | (арван найман сая таван зуун) | | |